



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/03

Өмнөдэлгэр сум

Ажил үүрэг гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай журам” -ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн дотоод хяналт шалгалтын багийн ажил үүргийг 2024–2025 оны хичээлийн жилд хариуцаж ажиллахыг (Э.Хэрлэн, Б.Наранчимэг, О.Бүрэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөх, хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа захиргааны хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг хамт олонд мэдээлж ажиллахыг дотоод хяналтын багийн ахлагч (Э.Хэрлэн)-д даалгасугай.

3. Сар бүрийн ажлын өдрүүдэд дотоод хяналтын багийн ахлагчийг нийт 16, гишүүд тус бүрийг сард нийт 8 илүү цагт ажил үүрэг гүйцэтгүүлж, ажил үүргээ гүйцэтгэсэн цагийн тооцоог хянан баталгаажуулж, тайлан, гүйцэтгэлийг үндэслэн тухайн жилийн цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг зохих журмын дагуу олгохыг нягтлан бодогч (М.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.СУГАРРАГЧАА

